



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 5/09

Хэрлэн сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.1.1, Хөдөлмөрийн гэрээний 4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн шийдлийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг дутуу байршуулсан, хуулийн хугацаа баримтлахгүй, хугацаа хоцроож мэдээлсэн Цэнхэрмандал сумын сургуулийн захирал Д.Цэцэгмаа, Баян-Овоо сумын сургуулийн захирал Ч.Болормаа, Өлзийт тосгоны сургуулийн захирал Б.Гантуяа, Хэрлэнбаян-Улаан тосгоны сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч Д.Хүрэлбаатар, Гурванбаян тосгоны цэцэрлэгийн эрхлэгч Л.Энхтуяа, Өлзийт тосгоны цэцэрлэгийн эрхлэгч Д.Гантуяа нарт сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

Хоёр. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг дээрх сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА